

Бүтээл нийтлэл илгээх тухай

Энэ удаа бид Монголын Нефрологийн Холбооноос эрхлэн “Бөөр судлал сэтгүүл” шинээр гаргахаар зорьж байна. Сэтгүүлд дараах хэлбэрээр бүтээл нийтлүүлнэ. Үүнд :

- Эрдэм шинжилгээний өгүүлэл
- Эмнэлзүйн тохиолдлын танилцуулга
- Хэвлэлийн тойм

Эрдэм шинжилгээний өгүүлэл (ЭШӨ) Гарчиг, хураангуй, түлхүүр үг, үндэслэл, материал арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, номзүй гэсэн бүтэцтэй. Зураг, хүснэгт, график зэргийг агуулж болно.

Эмнэлзүйн тохиолдлын танилцуулга (ЭТТ) Хүнд, ховор, оношилгоо эмчилгээг шийдэхэд бэрхшээлтэй эсвэл оношилгоо эмчилгээг амжилттай шийдсэн тохиолдлын тухай ирүүлнэ. ЭТТ нь гарчиг, хураангуй, түлхүүр үг, үндэслэл, тохиолдлын танилцуулга, хэлцэмж, дүгнэлт, номзүй гэсэн бүтэцтэй. Зураг, хүснэгт, график зэргийг агуулж болно.

Хэвлэлийн тойм (ХТ) Гарчиг, хураангуй, түлхүүр үг, үндэслэл, хэвлэлийн тойм, ном зүйг тус тус агуулна. Аль болох олон хэвлэлийн эх сурвалж ашигласан байна.

Бүтээл бичих заавар

1. Хэвлэлийн эх нь А4 цаасны нэг талд , Arial фондоор, гарчиг, дэд гарчиг үсгийн 12, текст нь үсгийн 11 хэмжээтэй, мөр хоорондын зай 1.15 sp, тал бүрээс 2 см зайтай.
2. ЭШӨ-ийг 4-8 нүүрт, ЭТТ-ийг 3-4 нүүрт, ХТ-ийг 4-8 нүүрт тус тус багтаана.
3. Судлаачдын нэрс, албан байгууллагын харъяалал, 1-р судлаачийн и-мэйл хаягийг баруун талд бичих.
4. Үр дүнг 4 хүртэлх тооны хүснэгт эсвэл зургаар илэрхийлнэ.

Бүтээлд тавигдах шаардлага

1. Бүтээл нь өмнө нь ямар нэг хэвлэлд хэвлэгдээгүй бүтээл байх.
2. Хураангуй нь англи хэл эсвэл эх хэл дээр бичигдсэн, 300-400 үг агуулсан байна. Түлхүүр үгэнд 5 хүртэл үгийг оруулна.
3. ЭШӨ-д судалгааны арга, аргачлал нь тодорхой бичигдсэн байх. Үр дүнд статистик боловсруулалт хийсэн байх.
4. Ном зүйд 20-оос доошгүй хэвлэлийн эх сурвалж ашиглана. Ишлэлийг [1] гэж тэмдэглэх.
5. Эх бичвэр нь техникийн болон үг үсэг, өгүүлбэр зүйн алдаагүй байх.

Бүтээлийг e-mail: mglassocationnephrology@gmail.com хаягаар хүргүүлнэ. Холбоо барих утас: 80441405. Судлаач эргэн холбоо барих утасны дугаар, e-mail хаягаа бичнэ.

Монголын Нефрологийн Холбоо

2021 оны 09 сарын 27